



**FIN AZ AUDIT**

**ФИН АЗ АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо

Энх тайваны өргөн, Экспресс тауэр 1503 тоот

Утас/Факс: 976-99104222, E-mail: finazaudit@gmail.com

2026-02-16 № А04/26

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-д

**“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК –ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД**

### **ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

Бид 2025 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй, санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК -ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

#### **Дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудиторын санал дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж үзэж байна.

#### **Аудитын гол асуудлууд**

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байдаг. Харин бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

#### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байдаг. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

#### **Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага**

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

### Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид:

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Гэхдээ алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- ✓ Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- ✓ Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхад материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт бид анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- ✓ Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

### Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаар

Монгол улсын Компанийн тухай хуулийн 92,94 дүгээр зүйлд заасны дагуу сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс тогтоосон бусад мэдээлэл, Компанийн дүрэмд заасан бусад мэдээллийг тайлагнах үүрэгтэй бөгөөд эдгээр зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

Бид санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор банк бус санхүүгийн байгууллагад мөрдүүлэхээр зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм, журмын хэрэгжилтийн талаар горим гүйцэтгэсэн бөгөөд дор дурдсан зөрчлийг эс тооцвол Монгол улсын хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм, журмыг ноцтойгоор зөрчсөн гэсэн үл үндэслэлтэй нотолгоо бидэнд ажиглагдаагүй болно. Үүнд:

- Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 2 дугаар сарын 25 -ны өдрийн 68 тоот тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын 3.22.2 -т заасан шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй байна.



## Бусад

Энэхүү тайланг аудитын тайлангийн өдөр буюу 2026 оны 02 дугаар сарын 16 -ны өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн ба уг өдрөөс хойших үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг аудитын тайланд тусгаагүй болно. Мөн энэхүү тайланг компанийн хувьцаа эзэмшигчид зориулан бэлтгэсэн бөгөөд бид тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ЗОЛЖАРГАЛ



“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК

2025 оны 12 сарын 31 –ний өдрөөрх

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Тодруулга	2025.01.01	2025.12.31
<b>ХӨРӨНГӨ</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1	2,736,633,073	4,653,507,716
Зээл	2	27,492,936,970	32,645,686,236
Факторингийн тооцооны авлага			
Үүсмэл санхүүгийн хөрөнгө			
Хөрөнгө оруулалт			
Бусад санхүүгийн хөрөнгө			
<b>Санхүүгийн хөрөнгийн дүн</b>		<b>30,229,570,043</b>	<b>37,299,193,952</b>
Татвар, НДШ -ийн авлага			
Үндсэн хөрөнгө	3	749,035,756	596,905,976
Биет бус хөрөнгө	4	2,434,082	2,773,760
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө			
Бусад санхүүгийн бус хөрөнгө	5	20,048,908	451,840,017
<b>Санхүүгийн бус хөрөнгийн дүн</b>		<b>771,518,747</b>	<b>1,051,519,752</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>31,001,088,790</b>	<b>38,350,713,704</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	6	5,073,715,404	9,948,471,851
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр			
Бусад эх үүсвэр			
Үүсмэл санхүүгийн өр төлбөр			
Бусад санхүүгийн өр төлбөр			
Хоёрдогч өглөг			
Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)			
<b>Санхүүгийн өр төлбөрийн дүн</b>		<b>5,073,715,404</b>	<b>9,948,471,851</b>
Татвар, НДШ -ийн өр төлбөр	7	311,824,232	396,910,970
Нөөц /Болзошгүй өр төлбөр /			
Хойшлогдсон татварын өр төлбөр			
Бусад санхүүгийн бус өр төлбөр	8	321,261	48,306,947
<b>Санхүүгийн бус өр төлбөрийн дүн</b>		<b>312,145,493</b>	<b>445,217,917</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>		<b>5,385,860,896</b>	<b>10,393,689,768</b>
<b>ӨМЧ</b>			
Хувьцаат капитал	9	4,600,000,000	6,040,000,000
Халаасны хувьцаа	10	-3,569,520	-3,569,520
Нэмж төлөгдсөн капитал	11	17,288,693,694	17,288,693,694
Өмчийн бусад хэсэг			
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	12	3,730,103,720	4,631,899,762
<b>НИЙТ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>25,615,227,894</b>	<b>27,957,023,937</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН</b>		<b>31,001,088,790</b>	<b>38,350,713,704</b>

Нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК

2025 оны 12 сарын 31 –ний өдрөөрх

АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

(төгрөгөөр)			
Үзүүлэлт	Тодруулга	2024 он	2025 он
<b>ХҮҮГИЙН ОРЛОГО</b>			
Банканд байршуулсан хөрөнгийн	13	207,514,099	169,698
Санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн			
Зээлийн	13	6,149,925,535	9,522,434,335
Үнэт цаасны			
Бусад			
(Хүүгийн орлогын буцаалт)	13	(8,040,292)	
Хүүгийн орлогын дүн		6,349,399,342	9,522,604,032
<b>ХҮҮГИЙН ЗАРДАЛ</b>			
Итгэлцлийн үр шим	13	886,479,755	1,288,307,183
Зээлийн			
Үнэт цаасны			
Бусад			
(Хүүгийн зардлын буцаалт)			
Хүүгийн зардлын дүн		886,479,755	1,288,307,183
<b>ХҮҮГИЙН ЦЭВЭР ОРЛОГО</b>		<b>5,462,919,586</b>	<b>8,234,296,849</b>
<b>Эрсдэлийн сангийн зардал</b>	14	469,928,740	2,143,207,597
<b>Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого (3-4)</b>		<b>4,992,990,846</b>	<b>6,091,089,252</b>
<b>Бусад орлого</b>			
Хүүгийн бус орлого	15	363,696,319	140,879,309
Бусад орлого, олз	16	955,000	501,020
<b>Бусад зардал</b>			
Хүүгийн бус зардал	17	1,189,996,556	956,296,225
Бусад зардал, гарз	18	38,359,517	133,187,963
<b>Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)</b>		<b>4,129,286,092</b>	<b>5,142,985,393</b>
<b>Орлогын татварын зардал</b>	19	422,343,981	525,637,837
<b>Татварын дараах ашиг, алдагдал (8-9)</b>		<b>3,706,942,111</b>	<b>4,617,347,556</b>
Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал			
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)			
Бусад дэлгэрэнгүй орлого			
<b>Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (12+13)</b>		<b>3,706,942,111</b>	<b>4,617,347,556</b>

Нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК

2025 оны 12 сарын 31 –ний өдрөөрх

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)					
ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	Нийт дүн
2025 оны 01 –р сарын 01 -ий үлдэгдэл	4,600,000,000	(3,569,520)	17,288,693,694	3,730,103,720	25,615,227,894
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					0
<b>Залруулсан үлдэгдэл 2024.12.31</b>	<b>4,600,000,000</b>	<b>(3,569,520)</b>	<b>17,288,693,694</b>	<b>3,730,103,720</b>	<b>25,615,227,894</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				4,617,347,556	4,617,347,556
Бусад дэлгэрэнгүй орлого					0
Өмчид гарсан өөрчлөлт	1,440,000,000				1,440,000,000
Хуваарилсан ногдол ашиг				(3,715,551,513)	(3,715,551,513)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					0
<b>2025 оны 12 -р сарын 31 -ий үлдэгдэл</b>	<b>6,040,000,000</b>	<b>(3,569,520)</b>	<b>17,288,693,694</b>	<b>4,631,899,762</b>	<b>27,957,023,937</b>

Нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.



“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК

2025 оны 12 сарын 31 –ний өдрөөрх

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2024 он	2025 он
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан	22,083,618,213	34,532,147,821
Итгэлцлийн үйлчилгээнээс хүлээн авсан	1,108,000,000	2,432,500,000
Факторингийн үйл ажиллагаанаас хүлээн авсан		
Бусад	120,599,975	331,507,574
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	<b>23,312,218,188</b>	<b>37,296,155,395</b>
Олгосон зээл	24,491,125,000	32,435,800,000
Буцаан олгосон итгэлцэл, үр шим	2,058,614,320	50,000,000
Факторингийн үйл ажиллагаагаар шилжүүлсэн		
Ажиллагсад олгосон	313,925,514	381,459,778
Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,094,798,195	1,167,013,869
Ашиглалтын зардалд төлсөн	40,314,600	386,695,367
Бусад	331,688,503	634,516,706
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	<b>28,330,466,132</b>	<b>35,055,485,719</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(5,018,247,944)</b>	<b>2,240,669,676</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө борлуулснаас хүлээн авсан		277,321,918
Хөрөнгө оруулалтаас хүлээн авсан	207,364,557	
Үнэт цаас борлуулснаас хүлээн авсан		
Бусад	208,776	
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	<b>207,573,333</b>	<b>277,321,918</b>
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	367,636,524	322,999,000
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Үнэт цаас олж эзэмшихэд төлсөн		
Бусад	12,677,657	
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	<b>380,314,181</b>	<b>322,999,000</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(172,740,848)</b>	<b>(45,677,082)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	9,884,912,523	
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	<b>9,884,912,523</b>	<b>0</b>
Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлд төлсөн		
Хоёрдогч өглөгт төлсөн		
Төлсөн ногдол ашиг	2,869,270,972	278,071,791
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	<b>2,869,270,972</b>	<b>278,071,791</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>7,015,641,551</b>	<b>(278,071,791)</b>
<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>(264,182,079)</b>	<b>(46,160)</b>
<b>БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>1,560,470,680</b>	<b>1,916,874,643</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,176,162,393	2,736,633,073
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,736,633,073	4,653,507,716

Нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.